



## ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Компанийн зохион байгуулалтын бүтэц,  
орон тооны дээд хязгаарт нэмэлт  
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт дараах нэмэлт өөрчлөлт оруулсугай.

- а) Бүтээмж хариуцсан менежер
- б) Хяналт хариуцсан менежер

2. Бүтээмж хариуцсан менежер, Хяналт хариуцсан менежерийн цалинг 2025 онд батлагдсан цалингийн санд багтаан олгохыг Гүйцэтгэх захирал /Э.Тамир/-т үүрэг болгосугай.

3. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн зохион байгуулалтын бүтцийн схемд нэмэлт өөрчлөлтийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

4. Дээрх албан тушаалтан нарын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, батлахыг Гүйцэтгэх захирал /Э.Тамир/-т үүрэг болгосугай.


5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Л.Амгалан/, Цалин урамшууллын хороо /Х.Ган-Очир/ нарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА

**"ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ" ТӨХХК  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ**



"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт